



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/32

Эрдэнэт хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/188 дугаар тушаал, "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалт, Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журмын 4.2 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орхон-А33А ТӨХК-ийн үйл ажиллагааны үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар тогтоосон акт, албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Орхон-А33А ТӨХК-н Төлөөлөн Удирдах Зөвлөл, Орхон-А33А ТӨХК-д тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгах, өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2018 оны 12 дугаар сарын 15-ны дотор ирүүлэхийг Орхон-А33А ТӨХК /Б.Цогтгэрэл/-д зөвлөсүгэй.
5. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг аудитын менежер /Б.Эрдэнэ/, аудитор /О.Дашжамц, О.Гантуяа/ нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитосын 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 32 дугаар тушаалын хавсралт

"Орхон-А33А ТӨХК-ний 2017 оны үйл ажиллагааны үр дүн" гүйцэтгэлийн аудитаар илэрсэн төлбөр зөрчлийн жагсаалт

/мян.төгрөг/

Ахын дугаар	Зөрчлийн товч утга	Төлбөр хариуцагч байгууллага	Төлбөр хариуцагчийн		Төлбөр	Зөрчил
			Албан тушаал	Нэр		
04/62-ОРА/2018/02-ГА	Жолоон Б.Шижирт ээлжийн амралтын цалинг 1 сард 409278 төгрөг, 11 сард 379900 төгрөг тус тус бодож 379927 төгрөгийг давхар олгосон, гэрээгээр ажиллаж байсан С.Одхүү нь 2018 оны 05 сард ажлаас чөлөөлөгдсөн байхад 06 сард үр дүнгийн нэмэгдэл цалин 48.0 мянган төгрөгийг илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.	Орхон-А33А ТӨХК	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч Тооцооны нягтлан бодогч	Б.Цогтгарал Ч.Жаргалмаа Т.Ганболд	427.9	
05/63-ОРА/2018/02-ГА	2017 оны кассын баримтаас 1-12 сард томилолтоор ажилласан хүмүүсийн томилолтын хуудсыг шалгахад томилолтын удирдамж, хуудасгүй, томилолтоор ажилласан хөногийг тооцохдоо явсан, ирсэн зам хөногийг нэг өдөрт тооцож хасалт хийлгүй томилолтын зардлыг илүү тооцсон, унааны зардлыг тасалбаргүйгээр нийт 603.5 мянган төгрөгийн томилолтыг илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоов.	Орхон-А33А ТӨХК	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Цогтгарал Ч.Жаргалмаа	603.5	
03/61-ОРА/2018/02-ГА	Биетээр байхгүй, дутаасан авто машины үнэ 641.3 мянган төгрөгийн үнийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.	Орхон-А33А ТӨХК	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч Тооцооны нягтлан бодогч	Б.Цогтгарал Ч.Жаргалмаа Т.Ганболд	641.3	
12/84-ОРА/2018/02-ГА	ТУЗ-ийн 2016 оны цалингаас 954.4 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцоогүй.	Орхон-А33А ТӨХК	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч Тооцооны нягтлан бодогч	Б.Цогтгарал Ч.Жаргалмаа Т.Ганболд		954.4
10/62-ОРА/2018/02-ГА	Мастер Б.Эрдэнэбаатарын 5-8 сарын цалингаас НДШ-ийг 7.8%-иар тооцон 75308 төгрөгийн НДШ дутуу, 7531 төгрөгийн ХХОАТ-ыг илүү суутгаж гарт олгох цалинг 67777 төгрөгөөр илүү, 2016 оны ТУЗ-ийн гашуудийн НДШ-ийг тооцож шилжүүлэхдээ 221269 төгрөгийн цалинг илүү тооцож 50000 төгрөгийн НДШ илүү шилжүүлсэн.	Орхон-А33А ТӨХК	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч Тооцооны нягтлан бодогч	Б.Цогтгарал Ч.Жаргалмаа Т.Ганболд		67.7
13/65-ОРА/2018/02-ГА	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэргүйгээр хөрөнгө оруулалтын		Гүйцэтгэх захирал	Б.Цогтгарал		1,761.6

		ТӨХК	Ерөнхий нягтлан бодогч	Ч.Жаргалмаа		
11/83-ОРА/2018/02-ГА	Шатахуун зарцуулалтыг анхан шатны баримтаас үзэхэд 186989.0 мянган төгрөгийн шатахууны зардал гарсныг орлого зарлагын баримт болон шатахуун олгох жагсаалтаар бүртгэсэн ч, захирлын 00-21 дугаартай ландкрузер машинд 5418.67 литр, 8263.4 мянган төгрөг, үйлчилгээний 98-31 дугаартай стана машинд 5419.7 литр, 8882.9 мянган төгрөг, 31-22 дугаартай жимбай машинд 10847.4 литр, 16542.3 мянган төгрөгийн бензин, шатахуун зарцуулсан анхан шатны баримт болох жагсаалтын тооцооны хуудасгүй зөрчил илэрсэн.	Орхон-А33А ТӨХК	Гуйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч Тооцооны нягтлан бодогч	Б.Цогтгэрэл Ч.Жаргалмаа Т.Ганболд		186,989.0
09/81-ОРА/2018/02-ГА	РСЦ ХХК-аас авах 45897.7 мянган төгрөгөөр авлагыг бүртгэх байтал 35897.7 мянган төгрөгийн авлагыг тайланд тусгаж, 10000.0 мянган төгрөгийн авлагыг дутуу тайлагнасан байна.	Орхон-А33А ТӨХК	Гуйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Цогтгэрэл Ч.Жаргалмаа		10,000.0
	Нийт дүн				1,672.7	199,772.7



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орхон авто зам засвар арчлалт төрийн өмчит хувьцаат компанийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



НББ-ийг хууль, журмын дагуу хөтлөөгүй, компанийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бус зарцуулсан байна.

Орхон аймаг
2018 он

АГУУЛГА

	Товчилсон үгийн жагсаалт.....	3
Аудитын тайланг бэлтгэсэн:	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, стандартын талаарх мэдэгдэл.....	4
	Үндсэн мэдээлэл.....	6
Орхон аймаг дахь Төрийн аудитын газар:	Бүлэг 1: 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшинг хугацаанд нь батлуулж, батлагдсан санхүүжилтийг бүрэн авсан ч, 125198.0 мянган төгрөгийн өглөгийг тайлан бүртгэлд тусгаагүй байна.	7
Дарга, Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах	1.1 ТУЗ-өөс компанийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшинг тогтоож, ТБОНӨТХ-ийн 21.2-д заасан хуулийн хугацаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж батлуулж ажилласан байна.	7
	1.2 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд төлөвлөгдсөн 718520.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авсан байна.	7
Аудитын менежер: Б.Эрдэнэ	1.3 Орлогын төлөвлөгөө 282,479.8 мянган төгрөгөөр тасарч, өмнөх оноос авлага 305,881.2 мянган төгрөгөөр, өр төлбөр 188,245.2 мянган төгрөгөөр өссөнөөс, 125,198.0 мянган төгрөгийн өглөгийг тайлан бүртгэлд тусгаагүй байна. А.2 Төрийн сангийн үйл ажиллагаанд хараат бус байдлыг хэрхэн хангах талаар зохицуулаагүй, аймгийн төвийн сумын санхүүгийн алба нь төлбөр тооцоо гүйцэтгэх программгүйгээс үндсэн чиг үүргийнхээ дагуу ажиллаагүй байна.	8
Аудитор: Д.Цогбадрах О.Дашжамц О.Гантуяа	Бүлэг 2: Компанийн зардлын гүйцэтгэл, зорилтот түвшний төлөвлөгөө бүрэн хангагдаагүй байна.	11
	2.1 Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг төлөвлөсөн хэмжээнд явуулж, байгалийн болзошгүй үер усны гамшигийг арилгах ажлыг нэмж гүйцэтгэсэн байна.	11
	2.2 Бараа материалыг анхан шатны баримтын бүрдэл дутуу, тайланд бүрэн тусгадаггүй, хуурамч бичиг баримт бүрдүүлж хөрөнгө зарцуулсан, ажилчидтай холбоотой зардлыг тооцоогүй, хяналтгүй зарцуулсан байна.	12
2018 оны 11 дүгээр сар	2.3 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт хангагдаагүй байна.Б.1 Төрийн сангийн төлбөр тооцоог хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа боловч алдаа, дутагдал гарсан байна.	14
Аудитын тайлан дүгнэлтэй холбоотой асуудлаар 70353088, 70350757, 70355805 дугаарын утсаар харилцана уу.	Бүлэг 3: Дотоод хяналт болон шилэн дансны хуулийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.	15
	3.1 Компани дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй ч бусад байгууллагын хяналт шалгалт хэрэгжсэн байна.	15
	3.2 Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч 2 мэдээлэл огт мэдээлээгүй, 28 мэдээллийг хугацаа хоцроосон, тушаал шийдвэрийг дутуу мэдээлсэн байна.	17
Уг тайланг УАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү. /www.audit.mn/	ДҮГНЭЛТ:.....	17
	ЗӨВЛӨМЖ:.....	18
	Хавсралт.....	19
Хаяг: Орхон аймаг дахь Төрийн аудитын газар Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон		

Орхон аймаг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл:**Аудит хийх үндэслэл**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан, Орхон аймаг дахь Төрийн Аудитын газрын 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Орхон Авто зам засвар арчлалт төрийн өмчит хувьцаат компанийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын зорилт

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлсэн. Үүнд:

- Орхон Авто зам засвар арчлалт төрийн өмчит хувьцаат компанийн санхүүжилт, орлого түүнийг бүрэн төвлөрүүлсэн эсэх
- Орхон Авто зам засвар арчлалт төрийн өмчит хувьцаат компанийн зардлын гүйцэтгэл, зорилтот түвшиний төлөвлөгөө бүрэн хангагдсан эсэх
- Дотоод хяналт болон шилэн дансны хуулийн хэрэгжилт хангагдсан эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитыг батлагдсан хуваарийн дагуу " Орхон Авто зам засвар арчлалт төрийн өмчит хувьцаат компани"-ийн 2017 оны жилийн санхүүгийн тайлан, касс харилцахын баримт, тушаал шийдвэр, компанийн дүрэм, дотоод журам болон бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудаас асуулга лавлагаа болон судалгаа авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудит хийсэн бүрэлдэхүүн

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Эрдэнэ үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Д.Цогбадрах, О.Гантуяа, О.Дашжамц нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

**Аудитад
ашигласан
шалгуур****Аудитын тайлан,
баталгаажуулалт:**

Аудитад дараах хууль, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Нэгдсэн төсвийн тухай хууль
- Авто замын тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Компаний тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- УИХ, ЗГ-ын холбогдох тогтоол, шийдвэрүүд, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргасан дүрэм, журам

Аудитыг 2018 оны 5 сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 31-ний хооронд хийж гүйцэтгэн холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“Орхон-АЗЗА” ТӨХК нь 1979 онд Хот хоорондын авто тээврийн 35-р баазын харьяа замын хэсэг нэртэйгээр анх байгуулагджээ. 2006 онд ТӨХ-ны 640 дүгээр тогтоол шийдвэрийн дагуу авто замын засвар арчлалтын байгууллагуудад бүтцийн өөрчлөлт хийж бие даасан компаниуд байгуулахтай холбогдуулан тусдаа гарч “Орхон-АЗЗА” ТӨХК нэртэйгээр 2012001001 дугаар бүхий улсын бүртгэлтэй, 338,367.1 мянган төгрөгийн дүрмийн сантайгаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлсэн.

А1001 дугаартай Дархан-Эрдэнэт чиглэлийн 108 км улсын чанартай хатуу хучилттай авто зам, А1002 дугаартай Эрдэнэт-Булган чиглэлийн 29.7 км хатуу хучилттай авто замуудын засвар арчлалтыг Орхон аймгийн хэмжээнд зохион байгуулж түүгээр өнгөрч буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн туршид саадгүй байлгах үүргийг бүрэн ханган ажиллаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу тус компанийн гүйцэтгэх захирал өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байна. Компани нь захиргаа аж ахуйн 5, санхүү хэлтсийн 4, инженер техникийн ажилчид 7, үйлдвэрлэлийн хэлтэст 29, нийт 45 ажилчидтайгаар, авто замын технологийн зориулалт бүхий 29 машин механизм тоног төхөөрөмж ашиглан, Зам тээвэр хөгжлийн сайдын 2016 оны 08 сарын 30-ны өдөр олгосон Б16/137 дугаар бүхий ЗБ-2-5 /3км -5 км хүртэл/ Хатуу хучилттай зам барих, ЗБ-1-5 /3км-5 км хүртэл/ Хучилтгүй зам барих, ЗМ-1 Зам барилга засварын материал, хийцийн үйлдвэрлэл, ЗЗА-1 Бүх төрлийн зам засварын ажил, ЗЗА-3 Зам талбайн тохижилтын ажил хийх, барих, засварлах ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Орхон-АЗЗА ТӨХК нь 2017 онд 1,146,575.1 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого олж, 1,121,930.2 мянган төгрөгийн зардал гарган, үндсэн үйл ажиллагаанаас 22,180.5 мянган төгрөгийн ашигтай ажиллажээ.

Санхүүгийн тайланд авлагыг 344,491.9 мянган төгрөг, богино болон урт хугацаат өглөгийг 804,251.2 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

Бүлэг 1. 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшинг хугацаанд нь батлуулан батлагдсан санхүүжилтийг бүрэн авсан ч, 125198.0 мянган төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаж тайлагнаагүй байна.

1.1 Компанийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшинг ТУЗ-аар хэлэлцүүлэн, ТБОНӨТХ-ийн 21.2-д заасан хуулийн хугацаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж батлуулж ажилласан байна.

Компанийн ТУЗ нь “Орхон-А33А” ТӨХК-ийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэн, 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталгаажуулан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж, батлуулан, мөрдөж ажиллах шийдвэр гаргажээ.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар нь 2016 оны 12 сарын 27-ны 289 дүгээр тогтоолоор “Орхон-А33А” ТӨХК-ийн 2017 оны бүтээгдэхүүн үйлдвэрлэлт буюу орлогыг 1,169,810.0 мянган төгрөг, зардлыг 1,143,293.6 мянган төгрөг, цэвэр ашгийг 23,864.8 мянган төгрөг, хөрөнгө оруулалтыг 58,495.0 мянган төгрөг, авлага 11,200.0 мянган төгрөг, өглөг 633,393.9 мянган төгрөг, борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал 0.98 төгрөг байхаар, компанийн бүтэц орон тоог захиргаа аж ахуйн хэсэгт дарга, ерөнхий инженер, эдийн засагч, хүний нөөц/хуулийн зөвлөх/, ерөнхий болон тооцооны нягтлан бодогч, касс болон аж ахуйн нярав, бичиг хэрэг/нарийн бичиг/, үйлчлэгч, жолооч нийт 11 ажилтан, Үйлдвэрлэлийн хэсэгт авто замын инженер, ХАБЭА-н инженер, мастер-3, механик, засварчин, үйлчилгээний жолооч 2, механизмчин 4, жолооч 4, сахиул 2, замчин 11, гэрээт ажилтан 4 нийт 34 бүгд 45 ажилтантай байхаар төлөвлөгөөг баталсан.

Гүйцэтгэлээр 1,146,575.1 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 1,121,930.2 мянган төгрөгийг зарцуулан 22,180.5 мянган төгрөгийн ашигтай ажилласан. Төлөвлөгөөнөөс ашиг 1,684.3 мянган төгрөгөөр буурсан байна. Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал 0.98 төгрөгийн биелэлттэй ажилласан байна.

Харин бүтэц орон тоо нь захиргаа аж ахуйн хэсэгт дарга, ерөнхий инженер, эдийн засагч, хүний нөөц/хуулийн зөвлөх/, ерөнхий болон тооцооны нягтлан бодогч, касс болон аж ахуйн нярав, бичиг хэрэг/нарийн бичиг/, үйлчлэгч нийт 10 ажилтан, Үйлдвэрлэлийн хэсэгт авто замын инженер, ХАБЭА-н инженер, мастер-3, механик, засварчин, үйлчилгээний жолооч 2, механизмчин 4, жолооч 4, сахиул 2, замчин 10, гэрээт ажилтан 2 нийт 31 бүгд 41 орон тоотой ажилласан байна. Үүнээс харахад гэрээт ажилтан олноор ажиллуулах шаардлагагүй байна.

Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс үзнэ үү.

1.2 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд төлөвлөгдсөн санхүүжилтийг бүрэн авсан байна.


ТӨБЗГ-ын 2016 оны 12 сарын 27-ны 289 дүгээр тогтоолоор “Орхон-А33А” ТӨХК-ийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингээр улсын чанартай авто замын санхүүжилтийн төлөвлөгөөг 718,520.0 мянган төгрөгөөр баталсан. Зам тээврийн хөгжлийн яамтай 2017 оны 01 сарын ..-ны өдрийн 43 дугаар гэрээгээр эхний хагас жилд 365,020.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаар гэрээг байгуулсан. 43

дугаар гэрээний нэмэлт гэрээ болох 2017 оны 11 сарын 30-ны өдрийн 295 дугаар гэрээгээр сүүлийн хагас жилд 454,950.0 мянган төгрөгийн санхүүжилт, 2017 оны санхүүжилтийн төлөвлөгөөг нийт 819,970.0 мянган төгрөгөөр шинэчилэн баталсан.

Гүйцэтгэлээр төлөвлөгөөт санхүүжилтийн 804,617.4 мянган төгрөг, онцгой ажлын /үер усны/ 53,712.4 мянган төгрөг, хулстайн гурван давааны засварын 24,988.6 мянган төгрөг, эрчимт хөдөлгөөний тооллогын 1,113.4 мянган төгрөг нийт 884,431.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авчээ.

Орлогын нэр төрөл	Батлагдсан төлөвлөгөө	Шинэчлэгдсэн төлөвлөгөө	Гүйцэтгэл
Улсын чанартай замын засварын санхүүжилт	718520.0	819970.0	884431.8

Зам засвар арчлалтийн батлагдсан төсвийг графикаар харуулбал:



1.3 Орлогын төлөвлөгөө 282,479.8 мянган төгрөгөөр тасарч, өмнөх оноос авлага 305,881.2 мянган төгрөгөөр, өр төлбөр 188,245.2 мянган төгрөгөөр өссөнөөс, 125,198.0 мянган төгрөгийн өглөг, 10,000.0 мянган төгрөгийн авлагыг тайлан бүртгэлд тусгаагүй байна.

2017 онд улсын чанартай авто зам засвар арчлалтын орлогыг 819,970.0 мянган төгрөг, орон нутгийн зам засварын ажлын орлогыг 571,672.9 мянган төгрөг нийт 1,391,642.9 мянган төгрөгийн ажил гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажилласан.

Гүйцэтгэлээр улсын чанартай авто зам засварын арчлалт болон нэмэлт ажлуудын 884,431.8 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөнөөс 64,461.8 мянган төгрөгөөр давж, харин орон нутгийн зам засварын 571,672.9 мянган төгрөгийн гэрээт ажлыг гүйцэтгэсэн ч 289,193.1 мянган төгрөгийн орлого орж 282,479.8 мянган төгрөгийн орлого тасарсан байна. Бусад гэрээт ажил болон түрээс, хүүгийн орлогоос 6,874.6 мянган төгрөг нийт 1,180,499.5 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн зам засварын 7,374.4 мянган төгрөгийн гэрээний дүнтэй “Булаг багийн 36-р гудамжны авто замын гарц барих”, 24,510.4 мянган төгрөгийн гэрээний

дүнтэй “Булаг багийн шороон зам сайжруулах” ажлуудад БЗА-141/17, БЗА-142/17 дугаар бүхий гэрээ байгуулан, туслан гүйцэтгэгчээр Хөх сүмийн хишиг ХХК-ийг ажиллуулан гэрээт ажлыг гүйцэтгүүлж тухайн онд орж ирсэн гэрээт ажлын орлого 26,092.5 мянган төгрөгийг өөрийн орлогоор бүртгэсэн. Тайлант онд Хөх сүмийн хишиг ХХК-д 26,092.5 мянган төгрөгийн өглөгийг тайланд тусгаагүй байтал 2018 оны 2 сард 23,483.2 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Мөн Өлзий хутагийн наран ХХК-ийн “Авто замын нөхөөс хийх” 77,379.9 мянган төгрөгийн гэрээт ажил, РСЦ ХХК-ийн гадна зам талбайн хэсэгчилсэн засварын 129,999.9 мянган төгрөгийн гэрээт ажлуудыг Орхон-А33А ТӨХК нь өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн ч гэрээний гүйцэтгэл гаргаагүй байна. Үүнээс дүгнэхэд орон нутгийн гэрээт ажлыг бодит гүйцэтгэлээр биш мөнгөөр орж ирсэн орлогын гүйцэтгэлээр тайланд тусгаж, борлуулалтын орлогыг бууруулж тайлагнасан байна. Гэтэл авлага өглөгийн тооцоо нийлэхдээ Өлзий хутгийн наран ХХК-аас авсан 262,238.2 мянган төгрөгийн асфальтны өглөгөөс 73,687.0 мянган төгрөгийн гэрээт ажлын орлогыг хасаж тооцоо нийлсэн. Мөн РСЦ ХХК-аас 84,102.2 мянган төгрөгийн бетон авсан өглөгийг гэрээт ажлын дүнгээс хасаж зөрүү дүн 45,897.7 мянган төгрөгөөр авлагыг бүртгэх байтал 35,897.7 мянган төгрөгийн авлагыг тайланд тусгаж, 10,000.0 мянган төгрөгийн авлагыг дутуу бүртгэсэн тул албан шаардлага хүргүүлэв.

Орон нутгийн зам засварын гэрээт ажлуудыг гүйцэтгэж дууссан ч улсын комисст хүлээлгэж өгөөгүйгээс Цагаанчулуут, Яргуйт, Даваат, Эрдэнэ багуудын замын ажлын 83,659.8 мянган төгрөг, 7 ажлын баталгааны 5% болон үлдэгдэл санхүүжилт 38,820.0 мянган төгрөг, туслан гүйцэтгэгчээр ажилласан “Харбин электрик интернейшнл” ХХК-наас авах 160,000.0 мянган төгрөг нийт 282,479.8 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлээгүй байна. Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос үзнэ үү.

Авлагын талаар:

Орхон-А33А ТӨХК нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 344,491.9 мянган төгрөгийн авлагатай тайлагнагдсан ба өмнөх оноос авлага 305,881.3 мянган төгрөгөөр өссөн байна. Харин 2017 оны зорилтот түвшинд авлагыг 11,200.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн ч авлагыг 333,291.9 мянган төгрөгөөр өсгөсөн нь зорилтот түвшинг хангаж ажиллаагүй байна. Энэ нь орон нутгийн замын гэрээт ажлыг хугацаанд нь хүлээлгэж өгөөгүй 119,142.2 мянган төгрөг, Харбин электрик интернейшнл ХХК-аас гэрээт ажлын хөлс 160,000.0 мянган төгрөгийг аваагүйгээс авлагын ихэнх буюу 81%-ийг эзэлж байна. РСЦ ХХК-аас авах 45,897.7 мянган төгрөгөөр авлагыг бүртгэх байтал 35897.7 мянган төгрөгийн авлагыг тайланд тусгаж, 10,000.0 мянган төгрөгийн авлагыг дутуу тайлагнасан байна.

2016 онд 4,623.5 мянган төгрөгийн шатахууны төлбөрийг илүү шилжүүлж авлага үүсгэж байсан. Мөн тухайн оны санхүүгийн жилийн хугацаа дуусаж байхад 2017 оны 12 сарын 25-нд “НИК” ХХК-д 62,495.4 мянган төгрөгийг шилжүүлж, 6,906.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна. ТӨБЗГ-ын бүртгэл хяналтын хэлтэсээс “Орхон-А33А” ТӨХК-ийн 2015, 2016 оны санхүүгийн үйл ажиллагааны шалгалтаар Булган-А33А” ТӨХК-тай холбоотой 2012 онд үүссэн 22,080.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах, шаардлагатай бол хууль хяналтын байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авах зөвлөмж хүргүүлсэн ч тодорхой ажил зохион байгуулаагүй байна.

Авлагын хүснэгт

/мян.төг/

Авлагын талаар 2017 он			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Харьцуулалт
Булган-АЗЗА ХХК	22,080.0	22,080.0	6.4
Бусад татвар	71.0	71.0	0.022
Хувь хүнээс авах авлага		381.3	0.112
НИК ХХК	4,623.6	6,906.0	2.005
Нийгмийн даатгалын хэлтэс		13.8	0.004
Орхон замын сан	7,416.7	119,142.2	34.58
РСЦ ХХК		35,897.6	10.42
Харбин интернешнл ХХК электрик		160,000.0	46.45
Орхон татварын хэлтэс	175.4		
Ажилчдын тооцоо	4,243.9		
Дүн	38,610.6	344,491.9	100

Өр төлбөрийн талаар:

2017 оны санхүүгийн тайланд богино хугацаат өр төлбөр 177,357.2 мянган төгрөг, урт хугацаат өр төлбөр 626,893.9 мянган төгрөг нийт өр төлбөрийг 804251.2 мянган төгрөгөөр тайлагнасан байна. Тайланд тусгаагүй “Өлзий хутагийн наран” ХХК-д асфальтны үнэ 101,714.8 мянган төгрөг, Булаг багийн шороон зам сайжруулах, Булаг багийн 36-р гудамжны авто замын гарцын гэрээт ажлуудад туслан гүйцэтгэгчээр ажилласан “Хөх сүмийн хишиг” ХХК-д гэрээт ажлын хөлс 23,483.2 мянган төгрөг нийт 125,198.0 мянган төгрөгийн өр төлбөрийг 2018 оны 1, 2 сард барагдуулсан байна.

Ажилчдын сар бүрийн цалингаас үйлдвэрчний эвлэлийн татварыг суутган тооцдог боловч тухай бүр үйлдвэрчний эвлэлийн дансанд шилжүүлдэггүй, жилийн нийт дүнгээр нь тухайн онд өр үүсгэн, дараа онд шилжүүлж байгаа нь Компанийн хамтын гэрээний 2.4-т “Үйлдвэрчний эвлэлийн хорооны бүх гишүүдийн хурлын шийдвэрийг үндэслэн гишүүдийн татварыг цалингаас бэлэн бусаар хураан, сар бүр ҮЭХ-ны дансанд шилжүүлнэ” заалтыг зөрчсөнд зөвлөмж хүргүүлэв.

Өр төлбөрийн хүснэгт

/мян.төг/

Өглөгийн талаар / 2017 он /			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Харьцуулалт
НӨАТатвар	94,101.8	164,996.0	18.21
ОТК ХХК	75.9	75.9	0.082
Орхон замын сан		3.0	0,0033
Татварын хэлтэс ХХОАТ	17,421.1	6,318.7	0.069
Татварын хэлтэс		2,289.1	0.025
Үйлдвэрчний эвлэлийн хороо	2,710.9	3,674.3	0.040
Урт хугацаат өр	626,893.9	626,893.9	69.2
Өлзий хутагийн наран ХХК		101,714.8	11.22
Дүн	741,203.7	905,965.7	100

Бүлэг 2. Компаний хөрөнгийг тооцоо, хяналтгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулж, худалдан авалтанд ТБОНӨХБАҮХАТХуулийг мөрдөж ажиллаагүй байна.

2.1 Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг төлөвлөсөн хэмжээнд явуулж, байгалийн болзошгүй үер усны гамшигийг арилгах ажлыг нэмж гүйцэтгэсэн байна.

Орхон АЗЗА ТӨХК нь А1001 дугаартай Дархан-Эрдэнэт чиглэлийн 108 км улсын чанартай хатуу хучилттай авто зам, А1002 дугаартай Эрдэнэт-Булган чиглэлийн 29.7 км нийт 137.7 км хатуу хучилттай авто замын засвар арчлалтыг хариуцан өвлийн 10,11,12,1,2 сард шуурхай ажлын хэсгийг ажиллуулан, цас цэвэрлэгээний ажлыг гүйцэтгэсэн.

Орон нутгийн замын тендерт оролцон 11 ажлыг гэрээгээр гүйцэтгэсэн. Мөн 5 аж ахуйн нэгж байгууллагуудад гэрээгээр ажил гүйцэтгэсэн. А1002 дугаартай Эрдэнэт-Булган чиглэлийн 29.7 км замыг дайрсан үер усны гамшиг болоход аймаг орон нутгийн байгууллагуудтай хамтран ажилласан байна.

2017 онд удирдлагын зардалд 174,828.5 мянган төгрөг, үйлдвэрлэлийн зардалд 947,101.7 мянган төгрөг нийт 1,121,930.2 мянган төгрөгийг зарцуулжээ.

Үйлдвэрлэлийн болон удирдлагын зардлын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Д/Д	Үзүүлэлт	2016 он		2017 он		/мян.төг/ Харьцуулалт	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төл/гүйц	2016/2017
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	272,553.2	273,346.1	286,221.0	261,361.4	91.3	95.6
2	НДШ	35,431.9	35,535.0	37,208.7	33,977.0	91.3	95.6
3	Түүхий эд материал	82,303.8	211,379.0	225,330.0	234,262.2	104	110.8
4	Түлш шатахуун	106,121.5	98,129.4	174,668.3	180,929.3	103.5	184.4
5	Сэлбэг хэрэгсэл	17,508.8	67,027.7	66,894.0	43,612.6	65.2	65.1
6	Томилолт /хээрийн/	8,997.0	13,989.6	8,997.0	15,332.6	170.4	109.6
7	Цахилгаан, дулаан	2,889.5	2,650.0	2,889.5	3,967.1	137.3	149.7
8	Хөдөлмөр хамгаалал	6,412.3	6,320.0	6,412.3	5,295.0	82.6	83.8
9	Түрээсийн зардал	9,000.0	8,420.0	9,500.0	4,545.5	47.8	54.0
10	Бичиг хэрэг	650.0	580.0	650.0	826.4	127.1	142.5
11	Бусад зардал /хан.мат/	8,850.0	31,683.0	9,500.0	22,202.7	233.7	70.1
12	Үндсэн хөрөнгийн элэгдэл	139,612.0	139,612.0	139,612.0	140,789.9	100.8	100.8
Нийт үйлдвэрлэлийн зардлын дүн		690,330.0	888,671.8	967,882.8	947,101.7	97.8	106.5
Удирдлагын зардлын дүн		186,731.5	192,922.1	175,410.8	174,828.5	99.6	90.6
Нийт зардлын дүн		877,061.5	1,081,593.9	1,143,293.6	1,121,930.2		

2.2 Бараа материалыг анхан шатны баримтын бүрдэл дутуу, тайланд бүрэн тусгадаггүй, хуурамч бичиг баримт бүрдүүлж хөрөнгө зарцуулсан, ажилчидтай холбоотой зардлыг тооцоогүй, хяналтгүй зарцуулсан байна.

Бараа материал: Орхон-АЗЗА ТӨХК 2017 онд 513,021.5 мянган төгрөгийн бараа, материал худалдан авч, 549,566.0 мянган төгрөгийн материалыг зарцуулснаар тайлагнасан байна.

Зам засварын ажилд зарцуулсан гэх 15,137.0 мянган төгрөгийн давс, 10,000.0 мянган төгрөгийн туузан хашлага, 13,200.0 мянган төгрөгийн замын бодис, хайрга, 17,820.0 мянган төгрөгийн замын тэмдэг тэмдэглэгээ, 7,320.0 мянган төгрөгийн асфальт, битумны үнэ, 4,125.0 мянган төгрөгийн арматурын төмөр зэрэг нийт 67,602.0 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан хэмээн хуурамч бичиг баримт бүрдүүлэн мөнгө зарцуулсан зөрчил илэрснийг хуулийн байгууллагад шилжүүлэв.

Эдгээр гүйлгээг хүснэгтээр дэлгэрэнгүй харуулбал:

/мян.төг/

д/д	Гүйлгээний утга	Огноо	Дүн	Борлуулагч
1	Давс авах	2017.01.31	1,460.0	“Ачуутсан” ХХК
2	Давс авах	2017.02.14	4,500.0	“Аниут” ХХК
3	Давс авах	2017.02.17	2,500.0	“Аниут” ХХК
4	Битум авах	2017.06.23	2,100.0	“Өлзий хутгийн наран” ХХК
5	Цас цэвэрлэгч бодис авах	2017.02.20	6,820.0	“Түмэн засал” ХХК
6	0.5 хайрга авах	2017.02.20	6,380.0	Удвал
7	Туузан хашлаганы урьдчилгаа	2017.07.06	10,000.0	“Ти Би Си Капитал” ХХК
8	Битум авах	2017.09.25	5,220.0	“Өлзий хутгийн наран” ХХК
9	Давс худалдан авах	2017.12.26	6,677.0	Ц.Алтангэрэл
10	Тэмдэг, тэмдэглэгээ	2017.07.06	6,000.0	“Мөнх Хүнхэр уул” ХХК
		2017.12.26	11,820.0	
11	Арматурын төмөр авах	2017.12.29	4,125.0	“Тэнгэрлэг цаг” ХХК
	Нийт		67,602.0	

“Өлзий хутгийн наран” ХХК нь 2017 оны 5 сарын 18-ны 09 дугаар гэрээгээр 450 тн, 09 сарын 11-ний 10 дугаар гэрээгээр 300 тн, 10 сарын 06-ны 10 дугаар гэрээгээр 300 тн нийт 204,750.0 мянган төгрөгийн 1,050.0 тн асфальт бетоныг Орхон-АЗЗА ТӨХК-д нийлүүлэхээр гэрээ байгуулсан байхад 262,238.2 мянган төгрөгийн 1,318.6 тн асфальтыг “Өлзий хутгийн наран” ХХК-аас авсан зарлагын баримт, тооцоо нийлсэн акт үйлдсэн ч Орхон-АЗЗА ТӨХК 2017 оны бараа материалын тайланд огт тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Эрдэнэт үйлдвэрийн “Дулааны цахилгаан станцын трубины өргөтгөл”-ийн ажлыг гүйцэтгэж буй БНХАУ-ын Харбин электрик интернэшнл ХХК-тай 200,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан, туслан гүйцэтгэгчээр ажиллаж, гаднах бетон замын хучилт болон явган хүний замын ажлыг гүйцэтгэсэн байна.

Уг ажилд 7,261.2 мянган төгрөгийн хайрга, элс, 4,401.5 мянган төгрөгийн цемент, 6,508.7 мянган төгрөгийн төмөр, төмөр эд зүйлс, 10,102.9 мянган төгрөгийн

замын хавтан, хашлага, 80,386.5 мянган төгрөгийн бетон зуурмаг, 5,274.9 мянган төгрөгийн бусад материал, нийт 113,935.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаар тайлагнасан байна. Орхон аймгийн цагдаагийн газарт тус компанийн гүйцэтгэх захирлын 2017 оны 10 сарын 13-ны 174 дугаар, 2017 оны 11 сарын 30-ны 218 дугаар бүхий албан бичгүүдэд гэрээт ажлын гүйцэтгэл 200.0 сая төгрөг өгөх байснаас 70.0 сая төгрөг урьдчилгаа болгон өгсөн, үлдэгдэл тооцоог дуусгавар болгоогүй тул шалгаж өгнө үү гэсэн албан тоот хүргүүлсэн боловч байгууллагын дансанд 40.0 сая төгрөг орсон зэрэг зөрчил илэрсэн тул хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.

Шатахуун зарцуулалтыг анхан шатны баримтаас үзэхэд 186,989.0 мянган төгрөгийн шатахууны зардал гарсныг орлого зарлагын баримт болон шатахуун олгох жагсаалтаар бүртгэсэн ч, захирлын 00-21 дугаартай ландкрузер машинд 5,418.6 литр, 8,263.4 мянган төгрөг, үйлчилгээний 98-31 дугаартай стана машинд 5,419.7 литр, 8,882.9 мянган төгрөг, 31-22 дугаартай жимбэй машинд 10,847.4 литр, 16,542.3 мянган төгрөгийн бензин, шатахуун зарцуулсан анхан шатны баримт болох жолоочийн тооцооны хуудасгүй байна. Байгууллагын хэмжээнд хэдэн литр шатахуун тайлант онд ашигласан нь тодорхой бус, компанийн бус авто машинууд компанийн нэр дээр шатахуун худалдан авч байгаа эсэхэд хяналт бүртгэл хангалтгүй байна. Шатахууны худалдан авалт болон зарцуулалт дээр хяналт тавьж, санхүү бүртгэлийг бүрэн хийх талаар албан шаардлага, зөвхөн байгууллагын автомашинд шатахуун олгох талаар худалдан авах гэрээнд нэмж тусгах зөвлөмж хүргүүлэв.

Тус байгууллагын аж ахуйн нярав, эд хариуцагчийн агуулахын бүртгэл хөтөлдөггүй, бараа материалын дэлгэрэнгүй тайлан гаргадаггүй байна. Компани хөрөнгийн тооллого хийдэг ч баталгаажсан тооллогын бүртгэлгүй, санхүүгийн программаар гаргасан тайлан тооллогын бүртгэлээс зөрүүтэй байна. Кассын нярав кассаас бэлэн мөнгө авч бараа материалын үнэнд төлөхдөө тухайн байгууллагад бус өөрийн компанийн дарга, нягтлан бодогч нараар дамжуулан өгдөг ч цаад байгууллагын бэлэн мөнгөний орлогын ордер байхгүй байна.

Цалин урамшуулал: 2017 онд ажилчдын цалингийн зардалд нийт 396,858.2 мянган төгрөгийг зарцуулснаас жолооч Б.Шижирт ээлжийн амралтын цалинг 1 сард 405.2 мянган төгрөг, 11 сард 379.9 мянган төгрөг тус тус бодож амралтын цалинг давхар олгосон, мөн гэрээтээр ажиллаж байсан С.Одхүү нь 2018 оны 05 сард ажлаас чөлөөлөгдсөн байхад 06 сард үр дүнгийн нэмэгдэл цалин 48.0 мянган төгрөг олгож, нийт 427.9 мянган төгрөгийн цалин илүү олгосонд төлбөрийн акт тогтоолоо.

Ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй, нөхөн амралт олгоогүйгээр санхүүгийн 3 ажилтанд 2230.8 мянган төгрөгийн амралтын цалинг шийдвэргүйгээр, цалинтай давхардуулан олгосон зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

2016 оны ТУЗ-ийн гишүүдийн цалингийн нийгмийн даатгалын шимтгэлийг тайлагнаагүй 4.5 сая төгрөгийг залруулахдаа 2017 оны нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаар тайлагнаж зардлыг өсгөсөн нь НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтыг зөрчсөн ба мөн 954.4 мянган төгрөгийн ХАОАТ-ийг суутган тооцоогүй, тайланд тусгаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Томилолт: 2017 оны кассын 1-12 сарын баримтаас томилолтын зардлыг шалгахад 2018 оны 03 сарын 16, 17-ны өдрүүдэд Улаанбаатар хотод 2017-ехро үзэсгэлэнд оролцсон Т.Чинтуяа, Ч.Алтангэрэл, С.Алтангэрэл нарт тус бүрт 1 хоног

илүү тооцон нийт 106.5 мянган төгрөг, 2018 оны 04 сарын 5-8-ны өдрүүдэд ТУЗ-ийн хуралд оролцсон Х.Батболд, Ч.Жаргалмаа, Л.Мөнхбат, Б.Бат-эрдэнэ нарт тус бүрт 1 хоног илүү нийт 142.0 мянган төгрөг, 2018 оны 09 сарын 29-нөөс албан ажлаар Х.Батболд, Ч.Жаргалмаа, Л.Мөнхбат нарт томилолтын хуудасгүйгээр тус бүрт 2 хоног нийт 213.0 мянган төгрөг, 2018 оны 12 сарын 26-наас Х.Батболд, Ч.Жаргалмаа нарт томилолтын хуудасгүйгээр тус бүрт 2 хоног нийт 142.0 мянган төгрөг нийт 603.5 мянган төгрөгийн томилолтын зардал илүү олгосонд төлбөрийн акт тогтоов.

Үндсэн хөрөнгө: Орхон-АЗЗА ТӨХК 2017 онд өөрийн хөрөнгөөр 1,761.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч бүртгэж тайлагнасан байна. ТӨБЗГ-ын 2017 оны 12 сарын 07-ны А-5/3481 дугаар тогтоолоор 15,247.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах тогтоол гарсан ч хөрөнгийг актлаагүй байна.

2017 оны жилийн эцэст нийт 1,397,526.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө тоологдсоноос 192,168.3 мянган төгрөгийн барилга байгууламж, 315,090.1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 853,560.1 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 35,607.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1100.0 мянган төгрөгийн программ хангамжийн үлдэгдэлтэй байгаа хэдий ч аудитын явцад хийсэн үндсэн хөрөнгийн тооллогоор хөрөнгийн дансанд бүртгэлтэй 641.3 мянган төгрөгийн Бенз авто машин байхгүй байгаа нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.”бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” заалтыг зөрчсөн тул үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгах, дутагдсан авто машиныг өөрийн хөрөнгөнд олж авах төлбөрийн акт тогтоов.

Мөн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа Жинбей микро автобус, Истана микро автобус, марк-2 суудлын авто машинуудыг данс бүртгэлд тусгаагүй, эзэмшлийг байгууллагын нэр дээр шилжүүлж аваагүй байгаа зөрчилд зөвлөмж өгөв.

2.3 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт хангагдаагүй байна.

Орхон-АЗЗА ТӨХК-ий ТУЗ-ийн 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 05 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг гүйцэтгэлийн хамт хүснэгтээр харуулав. Үүнд:

/мян.төг/							
д/д	Нэрс	Тоо хэм жээ	Төлөвл өгөөт өртгийн дүн	Зориулалт	Худалдан авах хууль зүйн зохицуулалтын арга	Тайлбар	Гүйцэтгэл
1	ПИКАП	1	18,000.0	ИТА-чдын замын хяналт болон үйлдвэрлэлийн хэрэгцээнд	ТБОНӨХБАҮХ АТХууль	ИТА-ын зам барилгын ажилд	0
2	Эксковатор	1	40,000.0	Үйлдвэрлэлийн шороон ухмалд	ТБОНӨХБАҮХ АТХууль	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд	0
3	Санхүүгийн программ шинэчлэлт	1	495.0	Санхүүгийн үйл ажиллагаанд программын шинэчлэлт хийлгүүлэх	ТБОНӨХБАҮХ АТХууль	НББ-ын MACS программын шинэчлэл хийлгэх	1,200.0
Нийт дүн			58,495.0				1,200.0

Дээрх баталсан төлөвлөгөөнөөс зөвхөн санхүүгийн программ шинэчлэлтийн ажлыг 1,200.0 мянган төгрөгөөр авч бүртгэлд тусгасан ч хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаагдаагүй, эрх бүхий байгууллагын шийдвэргүй 1,761.6 мянган

төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байх тул алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

Бараа материалыг бэлтгэхдээ хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаагүй буюу “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 8.4, 8.5, 21, 48, 49 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчин худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлан мэдээлээгүй, нээлттэй тендер зарлаагүй, харьцуулалтын аргаар ХАА-г зохион байгуулаагүй зэрэг нийт 178,449.4 мянган төгрөгийн зөрчил гаргасан байна. Энэ нь ТӨБЗГ-ын бүртгэл хяналтын хэлтэсээс 2017 оны 09 сард “Орхон-АЗЗА” ТӨХК-ийн 2015, 2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийхэд бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТХ журмыг мөрдөж ажиллаагүй зөрчил илэрч байсан нь дахин давтагдсаар байна. Үүнд:

/мян.төг/

д/д	Бараа бүтээгдэхүүний нэр	Нийт зардал	Зөрчил
1	Цемент	12,200.0	Харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт явуулаагүй.
2	Давс	32,437.0	Харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт явуулаагүй.
3	Будаг	21,000.0	Харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт явуулаагүй.
4	Замын тэмдэг, тэмдэглэгээ, хашлага	51,000.0	Нээлттэй тендер шалгаруулалт явуулаагүй.
5	Автогрейдерийн хутга	10,972.6	Харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт явуулаагүй.
6	Бусад сэлбэг хэрэгсэл, материал	50,844.8	Нээлттэй тендер шалгаруулалт явуулаагүй.
	Нийт	178,449.4	

Орхон-АЗЗА ТӨХК нь орон нутгийн зам засварын “Булаг багийн 36-р гудамжны авто замын гарц барих”, “Булаг багийн шороон зам сайжруулах” ажлуудын тендер оролцон захиалагчтай БЗА-141/17, БЗА-142/17 дугаар бүхий гэрээнүүд байгуулсан ч, зам гүүр барих тусгай зөвшөөрөлгүй “Хөх сүмийн хишиг” ХХК-аар гэрээт ажлыг гүйцэтгүүлсэн, мөн “Өлзий хутагийн наран” ХХК-ийн “Авто замын нөхөөс хийх” 77379.9 мянган төгрөгийн гэрээт ажлыг Орхон-АЗЗА ТӨХК гүйцэтгэсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т 50-иас доошгүй хувийг нь бие даан гүйцэтгэхээр ажил гүйцэтгэх тендер ирүүлсэн дараах этгээд: 10.1.2.а “Монгол улсын иргэн, хуулийн этгээд”, 10.1.2.б “Монгол Улсад бүртгэлтэй, өмчийнх нь 50-иас доошгүй хувь нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хувь хөрөнгөөс бүрдсэн гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Бүлэг 3. Дотоод хяналт болон шилэн дансны хуулийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

3.1 Компани дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй ч бусад байгууллагын хяналт шалгалт хэрэгжсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийг 2016 оны 09 сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар 9 гишүүн, 1 даргатайгаар байгуулсан байна. “Орхон-АЗЗА” ТӨХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2-т “Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 3 нь хараат бус гишүүн байна” заалтын дагуу Амгаланбаяр /Аз

Хур номын дэлгүүр/, Д.Эрдэнэбат /хувиараа ажил эрхэлдэг/, Ц.Одгэрэл /ЗТХЯ-нд ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан/ нар хараат бус гишүүнээр ажилласан байна.

Орхон-АЗЗА ТӨХК-ийн ТУЗ нь 2017 онд 5 удаа хуралдаж, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, аудитын хороо болон цалин урамшуулал, үнэлгээний хороо байгуулах, журмууд хэлэлцэх, 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2017 оны бизнес төлөвлөгөө батлах, бүтэц орон тоо батлах, цалин тогтоох, хөрөнгө оруулалт батлах зэрэг асуудлыг хэлэлцэж 12 тогтоол, 5 тэмдэглэл гаргасан байна. 2018 оны 1-р улиралд хуралдаж, 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж компанийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшингийн шалгуур үзүүлэлийн үнэлгээгээр 80.2%-тай дүгнэж, гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний биелэлтийг хангалттай гэж дүгнэсэн байна.

Компанийн гүйцэтгэх захирлын 2017 оны 03 сарын 06-ны өдрийн А/11 тоот тушаалаар дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэхээр 6 хүний бүрэлдэхүүнтэй комисс томилогдож, 11 чиглэлээр хяналт шалгалтыг зохион байгуулахаар ажлын төлөвлөгөө батлуулсан ч тухайн онд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Харин бусад байгууллагуудаас үндсэн үйл ажиллагаанд нь 3 удаагийн шалгалт хийгдэж илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах 1 тогтоол, 14 зөвлөмж, 2 дүгнэлт, 1 албан шаардлага, 1 төлбөрийн акт өгөгдсөн бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллах төлөвлөгөө гаргаж, биелэлтийг хүргүүлсэн байна. Тухайлбал:

1. ТӨБЗГ-ын бүртгэл хяналтын хэлтэсээс 2017 оны 09 сард “Орхон-АЗЗА” ТӨХК-ийн 2015, 2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж, шалгалтаар 532.6 сая төгрөгийн зөрчил дутагдлыг арилгах, арга хэмжээ авч биелэлтийг 2018 оны 1 дүгээр улиралд ирүүлэх тогтоол гаргасан байна.

2. МХЕГ 2017 оны 4 дүгээр сард нэгдсэн төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль болон бусад журам стандартын чиглэлээр нийт 10 төрлийн зөрчлийг арилгуулахаар 14-06-023/157 тоот албан шаардлага, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр 1152.0 мянган төгрөгийг төлүүлэх 14-06-023/30 тоот төлбөрийн акт тогтоожээ. Үүнээс 10 зөрчлийг арилгаж биелэлтийг хүснэгтээр гарган явуулсан байна. 2017 оны 10 сарын 18-нд 1152.0 мянган төгрөгийн төлбөрийг барагдуулсан байна.

3. Аймгийн МХГ-ын 2017 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу улсын чанартай авто замын засвар арчлалт хариуцсан байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, болзошгүй аюул осол, эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 14 зөвлөмж өгч, Зам тээврийн хөгжлийн яамны авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт 2 дүгнэлт хүргүүлсэн байна. Зөвлөмжийн 14 ажил тус бүрийг хийж гүйцэтгэсэн, А-1001 дугаартай замын 173+420-д байршилтай Эрдэнэт гүүрийг засварлах зураг төсөв хийлгэхээр ЗТХЯ болон ЗТХТ-д хүсэлт хүргүүлсэн байна.

Орхон-АЗЗА ТӨХК нь яам агентлаг, аймгийн Засаг даргатай гурвалсан гэрээ байгуулж ажилладаггүй. Харин Зам тээврийн хөгжлийн сайд, Орхон аймгийн Засаг дарга нарын хамтын ажиллагааны гэрээнд Сайдын хүлээх үүргийн 3.8-д “Сайдын багцад тусгагдсан улсын төсвийн хөрөнгөөр аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрч буй олон улсын болон улсын чанартай авто замын засвар арчлалтын ажлыг “Орхон-АЗЗА” ТӨХК-иар гүйцэтгүүлж, ажлын чанар байдалд хяналт тавьж, байнгын бэлэн

байдлыг хангуулна”, Засаг даргын хүлээх үүргийн 4.2.3-д “Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа олон улсын болон улсын чанартай авто замын урсгал засвар, арчлалтын ажилд хяналт тавьж, шаардлагатай дэмжлэг туслалцааг Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд үзүүлж байх”-аар заасны дагуу ХББЗА, ХЗА-наас хяналт тавьж ажилладаг байна.

3.2 Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч 2 мэдээлэл огт мэдээлээгүй, 28 мэдээллийг хугацаа хоцроосон, тушаал шийдвэрийг дутуу мэдээлсэн байна.

“Орхон-АЗЗА” ТӨХК нь Шилэн дансны хуулийн дагуу төсвийн болон улс орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн захирагчийн шийдвэр үйл ажиллагаа ил тод нээлттэй ойлгомжтой байхад нийцүүлэн <http://shilendans.gov.mn/> сайтад батлагдсан маягт, хавсралтуудын дагуу худалдан авах ажиллагаа, гарсан шийдвэр болон санхүүгийн тайлан тэнцлийн мэдээллийг сар бүр байршуулсан байна.

Нийт 62 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 32, хоцроосон 28, огт мэдээлээгүй 2 мэдээлэл байна. Худалдан авах ажиллагааны тайлан, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийн 12 сарын мэдээллийг огт мэдээлээгүй байна. Буцалтгүй тусламж, тэтгэвэрт гарахад олгосон тэтгэмж зэрэг 9 тушаал, сар шинийн баяр, ахмадын баяр болон ОУЭ-ийн баяр, хүүхдийн баярын зардлын 4 тушаал, зэргийн нэмэгдэл олгох 1 тушаал нийт 14 тушаалыг PDF файлаар оруулж, 9 тушаалыг мэдээлээгүй байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Компанийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшинг ТУЗ-аар хэлэлцүүлэн, ТБОНӨТХ-ийн 21.2-д заасан хуулийн хугацаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж батлуулж ажилласан байна.
- 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд төлөвлөгдсөн санхүүжилтийг бүрэн авсан байна.
- Орлогын төлөвлөгөө 282,479.8 мянган төгрөгөөр тасарч, өмнөх оноос авлага 305,881.2 мянган төгрөгөөр, өр төлбөр 188,245.2 мянган төгрөгөөр өссөнөөс, 125,198.0 мянган төгрөгийн өглөг, 10,000.0 мянган төгрөгийн авлагыг тайлан бүртгэлд тусгаагүй байна.
- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг төлөвлөсөн хэмжээнд явуулж, байгалийн болзошгүй үер усны гамшигийг арилгах ажлыг нэмж гүйцэтгэсэн байна.
- Бараа материалыг анхан шатны баримтын бүрдэл дутуу, тайланд бүрэн тусгадаггүй, хуурамч бичиг баримт бүрдүүлж хөрөнгө зарцуулсан, ажилчидтай холбоотой зардлыг тооцоогүй, хяналтгүй зарцуулсан байна.
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт хангагдаагүй байна.
- Компани дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй ч бусад байгууллагын хяналт шалгалт хэрэгжсэн байна.
- Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч 2 мэдээлэл огт мэдээлээгүй, 28 мэдээллийг хугацаа хоцроосон, тушаал шийдвэрийг дутуу мэдээлсэн байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын илрүүлэлт, аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Гүйцэтгэх захирал, нягтлан бодогч нарт:

- Компанийн үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, санхүүгийн үйл ажиллагаанд холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах,
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, худалдан авалтанд ТБОНӨХБАҮХАТ хуулийг мөрдөж ажиллах,
- Дотоод хяналтын комиссыг журмын дагуу ажиллуулах,
- Авлага, өр төлбөрийн тооцоо нийлж, тухай бүрт тайлан бүртгэлд бүрэн тусгах, шатахуун худалдан авагч байгууллагын гэрээнд зөвхөн байгууллагад бүртгэлтэй машинд шатахуун олгох талаар гэрээнд нэмж тусгах,
- Ажилчидтай холбоотой зардлын тооцоог тухай бүр хийж, ажилчдын ээлжийн амралтыг биеэр эдлүүлж, амралтын цалинг шийдвэргүйгээр давхардуулан олгохгүй байх,
- Үйл ажиллагаанд ашиглаж байгаа авто машинуудыг данс бүртгэлд тусгах, эзэмшлийг байгууллагын нэр дээр шилжүүлж авах,
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, эрх бүхий байгууллагын шийдвэргүй хөрөнгө бэлтгэхгүй байх, бараа материалыг хуурамч баримтаар орлогод авч зарцуулахгүй байх, шаардах хуудсанд, ямар ажилд зарцуулж байгааг бичиж байх,
- Булган-А33А ТӨХК-аас авах 22.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах.

Мэдэгдэл: Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож 2019 оны 05 дугаар сарын 20-ний дотор хариу ирүүлэхийг мэдэгдье.

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ЭРДЭНЭ

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР

Д.ЦОГБАДРАХ

АУДИТОР

О.ДАШЖАМЦ

АУДИТОР

О.ГАНТУЯА

Хавсралт № 01

“Орхон-А33А ТӨХК-ний 2017 оны үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудитаар илэрсэн төлбөр зөрчлийн жагсаалт

/мян.төгрөг/

Актын дугаар	Зөрчлийн товч утга	Төлбөр хариуцагч байгууллага	Төлбөр хариуцагчийн		Төлбөр	Зөрчил
			Албан тушаал	Нэр		
	Жолооч Б.Шижирт ээлжийн амралтын цалинг 1 сард 405278 төгрөг, 11 сард 379900 төгрөг тус тус бодож 379927 төгрөгийг давхар олгосон, гэрээтээр ажиллаж байсан С.Одхүү нь 2018 оны 05 сард ажлаас чөлөөлөгдсөн байхад 06 сард үр дүнгийн нэмэгдэл цалин 48.0 мянган төгрөгийг илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.	Орхон-А33А ТӨХК	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч Тооцооны нягтлан бодогч	Б.Цогтгэрэл Ч.Жаргалмаа Т.Ганболд	427.9	
	2017 оны кассын баримтаас 1-12 сард томилолтоор ажилласан хүмүүсийн томилолтын хуудсыг шалгахад томилолтын удирдамж, хуудасгүй, томилолтоор ажилласан хоногийг тооцохдоо явсан, ирсэн зам хоногийг нэг өдөрт тооцож хасалт хийлгүй томилолтын зардлыг илүү тооцсон, унааны зардлыг тасалбаргүйгээр нийт 603.5 мянган төгрөгийн томилолтыг илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоов.	Орхон-А33А ТӨХК	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Цогтгэрэл Ч.Жаргалмаа	603.5	
	Биетээр байхгүй, дутаасан авто машины үнэ 641.3 мянган төгрөгийн үнийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.	Орхон-А33А ТӨХК	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч Тооцооны нягтлан бодогч	Б.Цогтгэрэл Ч.Жаргалмаа Т.Ганболд	641.3	
	ТУЗ-ийн 2016 оны цалингаас 954.4 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцоогүй.	Орхон-А33А ТӨХК	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч Тооцооны нягтлан бодогч	Б.Цогтгэрэл Ч.Жаргалмаа Т.Ганболд		954.4
	Мастер Б.Эрдэнэбаатарын 5-8 сарын цалингаас НДШ-ийг 7.8%-иар тооцон 75308 төгрөгийн НДШ дутуу, 7531 төгрөгийн ХХОАТ-ыг илүү суутгаж гарт олгох цалинг 67777 төгрөгөөр илүү, 2016 оны ТУЗ-ийн гишүүдийн НДШ-ийг тооцож шилжүүлэхдээ 221269 төгрөгийн цалинг илүү тооцож 50000 төгрөгийн НДШ илүү шилжүүлсэн.	Орхон-А33А ТӨХК	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч Тооцооны нягтлан бодогч	Б.Цогтгэрэл Ч.Жаргалмаа Т.Ганболд		67.7
	Шатахуун зарцуулалтыг анхан шатны баримтаас үзэхэд 186989.0 мянган төгрөгийн шатахууны зардал гарсныг орлого зарлагын баримт болон шатахуун олгох жагсаалтаар бүртгэсэн ч, захирлын 00-21 дугаартай ландкурузер машинд 5418.67 литр, 8263.4 мянган төгрөг, үйлчилгээний 98-31 дугаартай стана машинд 5419.7 литр, 8882.9 мянган төгрөг, 31-22 дугаартай жимбэй машинд 10847.4 литр, 16542.3 мянган төгрөгийн бензин, шатахуун зарцуулсан анхан шатны баримт болох жолоочийн тооцооны хуудасгүй зөрчил илэрсэн.	Орхон-А33А ТӨХК	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч Тооцооны нягтлан бодогч	Б.Цогтгэрэл Ч.Жаргалмаа Т.Ганболд		186,989.0

РСЦ ХХК-аас авах 45897.7 мянган төгрөгөөр авлагыг бүртгэх байтал 35897.7 мянган төгрөгийн авлагыг тайланд тусгаж, 10000.0 мянган төгрөгийн авлагыг дууу тайлагнасан байна.	Орхон-АЗЗА ТӨХК	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Цогтгэрэл Ч.Жаргалмаа		10,000.0
Нийт дүн				1,672.7	199772.7